



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар A/88

Улаанбаатар хот

**Гурван шатны хяналтын үзлэг
зохион байгуулах тухай**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.2, 2.1, 2.3 дахь заалт, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2022 оны А/73 тушаалыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1. Үйлдвэрийн газрын Гурван шатны хяналтын үзлэгийг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх комиссын ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг зохион байгуулах гурван шатны хяналт үзлэгийн хүрээнд шаардагдах зардлыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Дуламханд)-д, Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг зохион байгуулах гурван шатны журамд нийцүүлэн гурван шатны хяналт шалгалтыг удирдамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамруулан хараат бус, ил тод, шударга, бодитой, нотолгоонд тулгуурлан гүйцэтгэж, үр дүнг нэгтгэн танилцуулахыг комисс (Д.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Д.Базарсад)-д, даалгасугай.

ЗАХИРАЛ



Х.ПҮРЭВЖАРГАЛ

16241186